



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 7 сарын 15 өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг татан буулгах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 124 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. “Балчирхан”, “Чингэлтэй үйлдвэр сургалтын төв”, “Хан-Уул хангамж”, “Сүх жанжин”, “Тахилт” нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Татан буугдаж байгаа нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын захирлыг 2005 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг харьяа дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Татан буугдаж байгаа нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын өр төлбөрийг байгууллага хүмүүстэй тооцоо нийлсэн дүн болон дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн хөрөнгийн орлогоос барагдуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т зөвшөөрсүгэй.

Дөрөв. Татан буугдаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, хаалтын балансыг 2005 оны 8 дугаар сарын 20-ны дотор гарган зохих байгууллагуудад ирүүлэхийг Татан буулгах комисс /Ц.Бат-Энх/-т даалгасугай.

Тав. Байгууллагын баримт бичгийг архивлан Нийслэлийн Архивын газар /С.Гаваа/-т, холбогдох журмын дагуу шилжүүлэхийг “Балчирхан” /Б.Баттөмөр/, “Чингэлтэй үйлдвэр сургалтын төв” /Ц.Балдангомбо/, “Хан-Уул хангамж” /С.Уртнасан/, “Сүх жанжин” /Н.Батбаатар/, “Тахилт” /Ч.Ганболд/ нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудад даалгасугай.

Зургаа. Ажилтан албан хаагчдад Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн зохих заалтын дагуу 1 сарын цалинтай тэнцэх тэтгэмж олгохыг комисст зөвшөөрсүгэй.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БЕГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

[Handwritten signature]
М.ЭНХБОЛД

Zaki-05-II

0200948



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
 ... сарын 15... ны өдрийн
 ... захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДЫГ
 ТАТАН БУУЛГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
 КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	Ц.Бат-Энх	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын орлогч дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Оюунгэрэл	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Мэргэжилтэн
	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Мэргэжилтэн
	Н.Буянхишиг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Мэргэжилтэн
	А.Нарангэрэл	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Мэргэжилтэн
	А.Нарантуяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хуулийн зөвлөх
	Б.Баттөмөр	“Балчирхан” НӨҮГ-ын захирал
	Г.Чулуунбат	“Балчирхан” НӨҮГ-ын нягтлан бодогч
	Ц.Балдангомбо	Чингэлтэй үйлдвэр сургалтын төв НӨҮГ-ын захирал
	Н.Наранжав	Чингэлтэй үйлдвэр сургалтын төв НӨҮГ-ын нягтлан бодогч
	С.Уртнасан	“Хан-Уул хангамж” НӨҮГ-ын захирал
	Ц.Цэцгээ	“Хан-Уул хангамж” НӨҮГ-ын нягтлан бодогч
	Н.Батбаатар	“Сүх жанжин” НӨҮГ-ын захирал
	Я.Гүндэгмаа	“Сүх жанжин” НӨҮГ-ын нягтлан бодогч
	Ч.Ганболд	“Тахилт” НӨҮГ-ын захирал
	Б.Баярмаа	“-Тахилт” НӨҮГ-ын нягтлан бодогч